



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 6/15

Баянхутаг

**Түлээ нүүрсний хөнгөлөлт
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5, 46 дугаар зүйлийн 46.3.3, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Монгол Улсын Соёлын Сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/390 тоот тушаал, байгууллагын дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023 оны үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн журмын үзүүлэлтийн 3 дэх хэсэгт зааснаар соёлын төвийн албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосугай.

2. Түлээ нүүрсний урамшуулал олгох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Албан хаагчдад олгогдох түлээ нүүрсний хөнгөлөлтийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1481600 (нэг сая дөрвөн зуун наян нэгэн мянга зургаан зуу) төгрөгийг зохих журмын дагуу бодож олгохыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.МӨНХХЭРЛЭН